

“ДЭЛГЭЦ” КИНО КОМПАНИ

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ



УЛААНБААТАР ХОТ 2011 ОН

“ЯЛАЛТ” КИНО ТЕАТР**ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ****1. Хөмрөг үүсгэгчийн түүх**

Тус байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 05 сарын 22-ны өдрийн 226 дугаар тогтоолоор Улаанбаатар Кино үзвэрийн контор нэртэйгээр Улсын кино үзвэрийн хэрэг эрхлэх газрын харьяанд байгуулагдаж, өөрийн гэсэн байргүйгээс “Ард” кино театрын 1 өрөөнд байрлан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Кино үзвэрийн конторын харьяанд тухайн үеийн кино театрууд болох Ард, Од, Элдэв-Очир, Хөдөлмөр, Сансар зэрэг хүүхдийн болон уран сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 кино театр, тэрчлэн нүүдлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг 17 нүүдлийн кино, хороодын улаан булангүүдын 14 суурин кино багтдаг байсан байна.

“Тус контор нь нийт 360 гаруй ажилтан, албан хаагчтай байсан ба анхны даргаар нь Ч. Дунхүү, 1975 оны 07 сарын 09-ний өдрөөс Б. Дамба нар тус тус томилогдон ажиллаж байжээ. Тэрчлэн кино үзвэрийн конторын дарга нараар дараах хүмүүс ажиллаж байжээ.

1. Ч. Дунхүү
2. Б. Дамба
3. н.Галбадрах
4. н.Нямдорж нар байсан.

ЗСБНХУ-ын /тухайн үеийн/ дээд зөвлөлийн дарга И.В. Падгорни 1973-1974 онд Монгол улсад айлчлахдаа 70/35 мм-ийн хэмжээтэй, дэлгэмэл дэлгэцтэй /широкий форматный/ кино театрын бүрэн тоног төхөөрөмжийг тус конторт бэлэглэсэн байна.

Энэхүү тоног төхөөрөмжийг ашиглахын тулд шинээр кино театр барих шаардлага тавигдсан ба улмаар 1975 онд “Ялалт” кино театрын суурийг тавьсан байна. Энэхүү кино театрын барилгыг монгол архитекторын боловсруулсан зураг төслөөр Улаанбаатар хотын барилга трестийн ажилчид 10 жилийн турш барьж дуусгасан ба Ялалтын баярын өмнөх өдөр буюу 1985 оны 05 сарын 01-ний өдөр нээлтээ хийжээ.

Тухайн үеийн Улаанбаатар хотын намын хорооны товчоо, Хотын АДХГЗ-ны тэргүүлэгчдийн хамтарсан хуралд шинээр байгуулагдсан кино театрны нэрийг “Өргөө” гэж нэрлэх саналыг дарга Б. Дамба оруулж, хурлын нарийн бичгийн дарга н. Адъяа уг асуудлыг эсэргүүцснээр агуу их ялалтын баяр тохиож байгаатай холбогдуулан “Ялалт” хэмээн нэрлэхээр тогтжээ.¹

Кино үзвэрийн конторын харьяа “Ялалт” кино театрны дэлгэцэнд гаргасан анхны кино нь “Хурд” нэرتэй кино байсан ба мөн энэхүү шинэхэн театрны дэлгэцнээ гарсан анхны монгол кино нь “Би чамд хайртай” байлаа.

“Ялалт” кино театрны даргаар нь:

- Д.Дарамсүрэн
- н.Бямбаа
- н.Одонгэрэл
- С. Жимээхүү
- Ч. Дунхүү нар ажиллаж байв.

“Ялалт” кино театрны бүтэц, зохион байгуулалт нь:

- Захиргааны алба /санхүү, аж ахуй/ 10 хүн
- Кино техникийн алба /7 хүн/
- Үйлчилгээний алба /10 хүн
- Цэвэрлэгээний алба 19 хүний бүрэлдэхүүнтэй буюу нийт 4 нэгжтэй, 46 ажилтан, албан хаагчтай байв.

Будаг нь үнэртсэн шинэхэн кино театр нь нэг ээлжиндээ 1200 хүнд үйлчлэх үзвэрийн их, бага 2 танхимтайгаас гадна 1, 2-р давхрын хүлээх танхимд уран зураг, фото зургийн үзэсгэлэн, телевизор, радио узель, зууш ундааны газар, ном, гоо сайхан, соёлын барааны худалдаа, холбооны цэгээр хөдөлмөрчдөд үйлчилж эхэлсэн байна.

“Дэлгэмэл дэлгэцийн “Ялалт” кино театр сүүлийн үеийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр 70мм, 35мм-ийн ердийн ба дэлгэмэл, өргөн хэмжээний киног дуу дүрс, өнгө гэрлийн дээд зэргийн чанартайгаар үзүүлж байжээ.

70 мм-ийн буюу дэлгэмэл дэлгэцийн кино зургийг 200 орчим шоо метр талбай бүхий дэлгэцээр үзүүлэхийн зэрэгцээ дуу бичлэгийн 6 сувгаар яриа, хөгжим, чимээг, стерео соронзон бичлэгээр үзэгчдэд хүргэж чадах өвөрмөц онцлогтой байсан байна.

¹ Кино үзвэрийн конторын дарга асан Б. Дамбын ярианаас

Кино театраас үзэгчдийн тавтай байдлыг хангахын тулд 1 цагт 120 мянган куб метр цэвэр тунгалаг агаар боловсруулан үйлдвэрлэж гаргадаг автоматик төхөөрөмжөөр үйлчилдэг байжээ. Мөн уран сайхны, баримтат, шинжлэх ухаан техникийн хялбарчилсан кино, “Кино мэдээ” сэтгүүл, зураасан зургийн болон хүүхэлдэйн бүх төрлийн киногоор үйлчлэхээс гадна олон улсын киноны наадам, үзлэг, шинэ киноны нээлт, уран бүтээлчид үзэгчдийн уулзалт, кино лекц, маргаан, үдэшлэг зэрэг соёл олон түмний сонирхолтой ажлууд тусгай хөтөлбөрөөр зохиогддог байжээ.

Үзэгчид кино эхлэх хүртэл радио узелээр дэлхийн сонгодог болон ардын, орчин үеийн дуу хөгжим, ухуулга мэдээллийн хэлбэртэй нэвтрүүлгийг тогтмол сонсох болсон.

Ялалт кино театрт дэлгэмэл дэлгэцийн кино урлагаар ЗХУ-д сургууль курс хийж, мэргэшиж ирсэн техникч Мандах, Тунгалаг, Шүрэнцэцэг нар болон 7-р таван жилийн гавшгайч МХЗЭ-ийн Төв хорооны шагналт Баянжаргал, Шүрэнцэцэг зэрэг өндөр мэргэжлийн хүмүүс ажиллаж байсан.²

“Дэлгэц” кино компани

“Кино үзвэрийн контор нь 1992 онд н. Нямдорж даргын үед татан буугдаж, “Улаанбаатар кино компани” болсон ба хуучин нэг удирдлагатай байсан кино театрууд бие даасан үйл ажиллагаа явуулах болж, “Ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Сүхбаатар дүүргийн Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас 1992 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн захирамжаар Ялалт кино театрыг Дэлгэц кино компани УҮГ болгон өөрчлөн зохион байгуулж, тус компаний захирлаар Ч. Дунхүүг томилж, дотоод дүрэм, журмыг баталсан³ байна.

Компанийн дүрэмд “Дэлгэц” кино компанийн удирдах дээд байгууллага нь Улаанбаатар хотын АХГЗ мөн гэж заасан байна.

“Дэлгэц” кино компани нь хуучин “Ялалт” кино театрын суурин дээр байгуулагдсан ба үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлж байсан байна. Бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөлт хийгээгүй ч орон тоогоо цөөрүүлж, 30 орчим ажилтан, албан хаагчтай болжээ.⁴

² Дэлгэмэл дэлгэцийн “Ялалт” кино театрын товч танилцуулга

³ НАГ, 110-р хөмрөг, 1-р данс, 9 ХН

⁴ О. Мандахын ярианаас

Байгууллагын эрхэм зорилт:

Нийслэлийн кино үзвэрийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн хөнгөн шуурхай соёлч байдлаар кино үзэгчдэд үйлчилгээ үзүүлэх.

Эрхлэх ажил үйлчилгээ:

- Хөдөлмөрчдөд дэлгэцийн болон дурс бичлэгийн кино үзвэрээр болон аж ахуйг өөрийн хөрөнгөөр хөгжүүлэн хөдөлмөрчдөд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх.
- Гадаад дотоодын киноны байгууллагуудтай кино солилцож, худалдаа хийж, хөдөлмөрчдөд кино үзвэрээр үйлчлэх,
- Дэлгэцийн болон дурс бичлэгийн кино бүтээх,
- Урлагийн төрөл бүрийн тоглолт хийлгэх,
- Байр тасгийг түрээслэж, төрөл бүрийн үйлчилгээ явуулах,

Улаанбаатар хотын “Дэлгэц” кино компанийн захирлын 1994оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 142 дугаар тушаалаар “Захиргаа аж ахуйн тасаг”-ийг шинээр байгуулж, дарга няравын орон тоотойгоор ажиллуулж эхэлсэн байна.

Энэхүү тасаг нь театрын захиргаа, ариун цэвэр тохижилт аж ахуйн асуудлыг хариуцан, даргаар нь П. Сумхүү ажиллаж байжээ. Мөн компанийн захирлын 2000 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 24 тоот тушаалаар тус компанийн менежментийг сайжруулах зорилгоор

- “Үзвэр үйлчилгээний алба”
- “Аж ахуй, техник засвар хангамжийн асуудал эрхэлсэн алба”-ыг шинээр байгуулахын зэрэгцээ дэд захирлын болон инженерийн, мөн техникичийн орон тоог хасч, ахлах кино механикч, билет шалгагч- үйлчлэгчдийн ахлагч, хяналтын хаалгачийн орон тоог нэмэгдүүлсэн байна.

Үзвэр үйлчилгээний алба

Кино зураг олох, үзвэрийн хөтөлбөр зохиож хэрэгжүүлэх, үйлчилгээнд хөнгөн шуурхай, соёлч, ариун цэвэрч байдлыг хэвшүүлэх үүрэгтэй байв.

Аж ахуй, техник засвар хангамжийн асуудал эрхэлсэн алба

Киноны тоног төхөөрөмж болон цахилгаан, сантехникийн талаар доголдолгүй ажиллуулж, кино механикчид, слесарь зэрэг мэргэжлийн ажилтнуудын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх үүрэгтэй үйл ажиллагаа явуулж байв.

“Улаанбаатар синема” ХХК-ийн “Тэнгис” кино театр

Нийслэлийн засаг даргын 2003 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 289 дүгээр захирамжаар “Дэлгэц” НӨҮГ-ыг татан буулгаж, Нийслэлийн өмчийн оролцоотой, Монгол-Солонгосын хамтарсан хөрөнгө оруулалттай “Улаанбаатар синема” ХХК-ийг 2003 оны 08 дугаар сарын 01-ний өдөр үүсгэн байгуулж, жилдээ 800,000 иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэн, нийслэлийн хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа явуулж байна.

“Улаанбаатар синема” ХХК нь Skytel компанийн байранд байрладаг байсан ба 2004 оны 02 дугаар сард Солонгосчууд хуучин “Ялалт” кино театрын барилгад капитал засвар хийж, “Улаанбаатар синема” ХХК-ийн “Тэнгис” кино театр 2004 оны 03 дугаар сарын 05-ны өдөр нээлтээ хийж, 1000 хүний суудалтай 2 танхимыг 378, 420, 204 хүний суудалтай 3 танхим болгон өөрчлөн зохион байгуулж, кино үзвэрийн хамгийн сүүлийн үеийн Германы “KINOTON” фирмийн техникеэр иж бүрэн тоноглогдсон бөгөөд нэгэн зэрэг 1004 хүнд үйлчлэх хүчин чадалтай, монгол болон дэлхийн бусад орнуудын шилдэг кинонуудыг 35 мм-ийн кино хальс ба 3D технологийг ашиглан жилд 600-700 мянган иргэдэд үйлчилж байна.

“Тэнгис” кино театр ашиглалтанд орсноор сүүлийн 10 гаруй жил уналтанд ороод байсан мэргэжлийн кино үзвэрийн үйл ажиллагааг шинэ шатанд гарган иргэдийн кинонд хандах хандлагыг өөрчилж чадсан байна.

Энэ нь монгол киноны хөгжилтөнд тодорхой хэмжээгээр нөлөөлж, монгол залуусын оюун ухаан, авьяас чадвараар бүтээгдсэн олон сайхан кинонууд ар араасаа цувран гарч байна.

“Тэнгис” кино театр кино үзвэрийн үндсэн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ түргэн хоолны газар, автомат тоглоомын төв, цэцэг, бэлэг дурсгалын дэлгүүр, залуусын хувцасны дэлгүүр, Skytel, Univision зэрэг компаниудын үйлчилгээний төв, Голомт, ХААН, Хадгаламж банкуудын ATM зэргийг байршуулан хэрэглэгчдийн ая тухтай үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх тал дээр анхаарлаа хандуулан ажиллах болсон байна.

Өнгөрсөн хугацаанд Мягмар гаригт “Хосуудын өдрийн хөнгөлөлт”, Лхагва гаригт “Оюутан залуусын өдрийн хөнгөлөлт”, Улаан фенийн картын урамшуулал, “Төрсөн өдрөө Тэнгист үнэгүй” зэрэг хөнгөлөлт урамшууллын үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэн иргэдэд чанартай соёлтой үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилт тавин ажиллаж ирсэн байна.

“Тэнгис” кино театр нь:

- | | |
|---------------------------------|---|
| 1. Захиргааны алба | 4 хүн |
| 2. Санхүүгийн алба | 4 хүн |
| 3. Маркетингийн алба | 4 хүн |
| 4. Инженер техникийн алба | 5 хүн |
| 5. Кино прожекшний /projection/ | 5 хүн |
| 6. Үйлчилгээний алба | 20 хүн |
| 7. Цэвэрлэгээний алба | 20 хүн |
| 8. Харуулын алба | 12 хүний бүрэлдэхүүнтэй нийт 8 алба, 90-ээд ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна. |

“Тэнгис” кино театр нь нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, зорилтынхоо хүрээнд дараах шагнал урамшууллыг хүртэж ирсэн байна. Үүнд:

- 2005 онд Нийслэлийн шилдэг гэрэлтүүлэгтэй байгууллага
- 2006 онд Нийслэлийн Боловсрол шинжлэх ухааны газар Монголын сурагчдын холбооны хамтарсан “Хүүхдэд ээлтэй байгууллага”
- 2007 онд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Шилдэгийн шилдэг аж ахуйн нэгж шагнал
- 2008 онд Монголын Оюутны холбооны дээд шагнал “Оюутан залуучуудын төлөөх хүндэт цом”
- 2009 онд Үндэсний татварын газар: Найдвартай татвар төлөгч
- 2011 онд Татварын ерөнхий газар: Найдвартай татвар төлөгч зэрэг шагналуудаар шагнагдан амжилттай ажиллаж байна.

⁵ О. Мандахын ярианаас

2. Хөмрөг үүсгэгчийн баримтын түүх

Тус байгууллага нь Нийслэлийн Архивт 2003 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Дэлгэц” кино компани нэртэйгээр 1991-2003 оны 13 ХН-тэй 110 дугаар хөмрөгийг үүсгэжээ. Уг хөмрөгт 1991-1993 оны “Ялалт” кино театрын захирлын тушаал 3 ХН, “Дэлгэц” кино компанийн захирлын тушаал 5 ХН, компанийн жилийн эцсийн тайлан тэнцэл 5 ХН-р тус тус нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.

“Ялалт” кино театрын үйл ажиллагааны явцад хөтлөгдсөн удирдлагын болон санхүүгийн цөөн хэдэн баримт Нийслэлийн архиваас өөр байгууллага, архивт хадгалагдаагүй ирсэн ба баримтын бүрдэл маш хангалтгүй байна.

Кино үзвэрийн конторын дарга асан, “Ялалт” кино театрын ууган ажилтан Б. Дамбын ярьж байснаар Кино үзвэрийн контор татан буугдаж, түүний харьяа кино театруудын баримтыг төрийн архивт шилжүүлэлгүй 1989-1990-ээд оны үед тэдгээр баримтыг машинаар зөөн шатаахад, тухайн үеийн киноны плёнк шатахад бэрх, их цаг хугацаа зарцуулсан гэсэн мэдээлэл өгсөн.

“Дэлгэц” кино компанийн 1989-2003 оны архивын баримтад 2003 оны 07 дугаар сарын 21-нээс 08 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд Нийслэлийн Архивын газрын архивч У. Золзаяа ЭШТБ-ын ажлыг “Байгууллагын архивын ажлын заавар”-ын дагуу хийж гүйцэтгэжээ. ЭШТБ-ын ажлыг хийх явцад: баримтын агуулга, нэр төрөл, зохион байгуулалт, он цагаар нь ангилан ялгаж, шаардлагатай хадгаламжийн нэгж, хуудсыг сэлбэн засах, үдэж хавтаслах, хуудас дугаарлах, баталгаа ашиглалтын хуудас бөглөх, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба баримтын бүрдэл дутуу, хурлын тэмдэглэл огт байхгүй байсан байна.

ЭШТБ-ын ажлын үр дүнд байнга хадгалах 1991-2003 оны 13 ХН-ийн данс, түр хадгалах 1993-2003 оны 119 ХН-ийн бүртгэл, 70 жил хадгалах 1989-2003 оны 8 ХН-ийн бүртгэлийг тус тус үйлдэж Нийслэлийн Архивын албаны дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан байна.

Баримтын бүрдэлд Ялалт кино захирлын захирлын тушаал 3 ХН, “Дэлгэц” кино компанийн захирлын тушаал 5 ХН, компанийн жилийн эцсийн тайлан тэнцэл 5 ХН байх ба маш дутуу бүрдэлтэй байна. Баримтууд цаасан суурьтай, биологийн болон хими физик, механик гэмтэлгүй, хадгаламжийн 1 дүгээр санд хадгалагдаж байна.

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ ҮЙЛДСЭН:

НИЙСЛЭЛИЙН АРХИВЫН ГАЗРЫН



ГЭРЭЭТ АРХИВЧ, СЭЛБЭН ЗАСАГЧ: *Ю.Дуламрагчай* Ю. ДУЛАМРАГЧАА

ХӨМРӨГҮҮСГЭГЧИЙН НЭР, ХАРЬЯАЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Дээд байгууллагын шийдвэр, огноо	Нэрийн өөрчлөлт
БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1975.05.22-ны өдрийн 226-р тогтоол	Кино үзвэрийн контор
1985.05.01	Кино үзвэрийн конторын харьяа “Ялалт” кино театр
Сүхбаатар дүүргийн Ардын хурлын гүйцэтгэх захиргааны 1992.08.20-ны өдрийн захирамж	“Дэлгэц” кино компани
2003.08.01	“Улаанбаатар синема” ХХК
2004.03.05	“Улаанбаатар синема” ХХК-ийн “Тэнгис” кино театр

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Товчлол	Тайлал
1	2	3
1	АДХГЗ	Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа
2	ББНШАЗК	Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс
3	БНМАУ	Бүгд найрамдах Монгол ард улс
4	ЗСБНХУ	Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс
5	ИТА	Инженер техникийн алба
6	KYK	Кино үзвэрийн контор
7	МХЗЭ	Монголын хувьсгалт залуучуудын эвлэл
8	НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
9	Сн3	Сайд нарын зөвлөл
10	ҮҮГ	Улсын үйлдвэрийн газар
11	ХН	Хадгаламжийн нэгж
12	ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
13	ЭШТБ	Эрдэм шинжилгээ техник боловсруулалт



Кино үзвэрийн конторын харьяа “Ялалт” кино театр /1995 он/



“Улаанбаатар синема” ХХК-ийн “Тэнгис” кино театр /2003 он/

ДҮГНЭЛТ

“Ялалт” кино театр нь анх 1985 онд нээлтээ хийж, Улаанбаатар хотын кино театруудын тоог нэгээр нэмж, анхны киногоо үзэгч олондоо хүргэн үйлчилж эхэлсэн билээ. Гадаад дотоодын дан ганц кино гаргахаас гадна нийтийг хамарсан соёл олон түмний олон ажлуудыг зохион байгуулж байснаар Нийслэлийн хөдөлмөрчдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, очих дуртай газруудын нэг болжээ.

1990-ээд он буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үед хүмүүсийн кино үзэх явдал нь багассан ба тэр ч утгаараа нэгдсэн удирдлагатай байсан кино театрүүд аж ахуйн нэгжийн хуулиар бие даан үйл ажиллагаа явуулах болсон байна.

Кино үзвэрийн kontорын харьяа “Ялалт” кино театрыг 1992 онд “Дэлгэц” кино компани болгон өөрчлөн зохион байгуулсан нь техник технологи тодорхой хэмжээгээр хөгжиж, түүнийг дагаж үйлчилгээний шаардлага, мэдээлэл технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах хэрэгтэй болсон. Нийгмийн хэрэгцээ шаардлагын хүрээнд үйл ажиллагааны чанар, бодлого, менежмент алхам алхамаар урагшлах арга хэмжээний 1 байлаа. Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээгээ өргөтгөж, 70 мм-ийн буюу дэлгэмэл дэлгэцийн кино зургийг 200 орчим шоо метр талбай бүхий дэлгэцээр үзүүлэхийн зэрэгцээ дуу бичлэгийн 6 сувгаар яриа, хөгжим, чимээг, стерео соронзон бичлэгээр үзэгчдэд хүргэдгээрээ бусад кино театрудаас онцлогтой байсан нь харагдаж байв.

“Дэлгэц” кино компанийг 2003 онд татан буулгаж, суурин дээр нь Монгол Солонгосын хамтарсан хөрөнгө оруулалттай “Улаанбаатар синема” ХХК-ийн “Тэнгис” кино театрыг байгуулан, сүүлийн жилүүдэд уналтанд ороод байсан Монголын киноны хөгжилтэнд тодорхой хэмжээгээр нөлөөлж, гадаадын болон дотоодын олон сонирхолтой киноуудыг үзэгч олондоо хүргэхийн зэрэгцээ хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цөөн хэдэн газрын нэг болж, үйл ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлсээр байна.

Энэхүү салбар нэгжийн түүхээс харахад бусад кино театрудаас хамгийн анх шинэчлэгдэж, орчин үеийн техник технологийн шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж ажиллаж байгаа кино театр нь “Тэнгис” кино театр байгаад ихэнх хүмүүс санал нийлэх буйзана.

Дэлхийн хэмжээнд гарч буй шинэ кинонуудыг тухай бүр кино театртаа нээн гаргаж, Монголдоо анхдагч байж чаддаг төдийгүй, бүтэц, зохион байгуулалт, шинэлэг тоног төхөөрөмж, кино сонголт, үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангах, маркетингийн бодлогын хувьд оновчтой, зөв шийдэлтэй ажилладагаараа салбартаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байна.

Энэхүү түүхчилсэн лавлахыг бичихэд түүхэн баримт ховор байсан төдийгүй өнгөрсөн амьдралаас түүх болон үлдэх ховор нандин баримтуудыг устгаснаар өнөөдөр тухайн үеийн соёлын томоохон байгууллагын ганц ч болов зураг архиваас шүүгээд олдохгүй байгаа нь туйлын харамсалтай байв. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулж байх үед үүсэл хөгжил, түүхийн талаар ямар нэг ном, гарын авлага, танилцуулга /брошур/ гаргасан зүйлгүй, Кино үзвэрийн kontорын даргаар ажиллаж байсан Б. Дамба, Ялалт кино театрт ажиллаж байсан инженер О.Мандах /одоо Тэнгис кино театрт, инженер техникийн албаны даргаар ажиллаж байгаа/ нарын аман ярианаас зарим мэдээ сэлтийг авч, түүхээ арвижууллаа.

Байгууллагын түүх болон ялангуяа архивын баримтын бүрдэл, нөхөн бүрдүүлэлт хадгалалт хамгаалалт, ашиглалтын асуудалд товч дүгнэлт хийхэд цаашид татан буугдсан, хувьчлагдсан, менежментийн хувьчлалд орсон буюу бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсон байгууллагууд тухай бүр төрийн архивт баримтаа шилжүүлж байх, уг асуудлаар нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтын түвшинд хариуцаж ажилладаг Нийслэлийн өмчийн харилцааны газартай төрийн архивын зүгээс уялдаа холбоотой ажиллаж, Нийслэлийн түүхийг устаж үгүй болох нөхцөл дээр анхаарч ажиллах шаардлага гарч байна.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:

НИЙСЛЭЛИЙН АРХИВЫН ГАЗРЫН
ГЭРЭЭТ АРХИВЧ, СЭЛБЭН ЗАСАГЧ: *Ю. Дуламрагчай* Ю. ДУЛАМРАГЧАА

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

1. Архив, албан хэрэг хөтлөлттэй холбогдсон хууль тогтоомжийн эмхэтгэл-2 2005 он УБ хот
2. Сан хөмрөг үүсгэгчдийн түүхчилсэн лавлах 2008 он УБ хот
3. Төрийн архивын ажлын үндсэн заавар 2008 он УБ хот
4. Ахмадуудын яриа, дурсамж /
5. НАГ-ын 110 дугаар хөмрөгийн баримт